

**ХЯТАДЫГ СУДЛААЧ ЯПОН
ЭРДЭМТНИЙ ШИНЭ
БҮТЭЭЛИЙН ТУХАЙ**

М. НАКАЖИМА «Жюүнэнго-но Чюроку»
(10 жилийн дараах Хятад улс), Токио,
1986, х. 283

Токиогийн Гадаад хэлний дээд сургуулийн профессор, нийгэм судлалын ухааны доктор Накажима Минэо хятадын судлалаар 30 орчим жил ажиллаж, «Хятад улс: түүх, нийгэм, гадаад харилцаа», «Соёлыг дахин бүтээхийг зорьж байгаа Хятад улс», «Орчин үеийн Хятадын улс төр, стратеги» зэрэг олон ном бичиж хэвлүүлжээ.

М. Накажима 1986 онд хэвлүүлсэн «10 жилийн дараах Хятад улс» хэмээх номоо Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийн цаашдын төлөвийн асуудалд зориулжээ. Зохиогч «Хятад улс хойшид хэрхэн хөгжих вэ, 10 жилийн дараа (2000 он гээд) Хятад улс ямаршуу байдалтай байх вэ? гэдэг асуудал Хятадын өөрийнх нь хувьд ч, дэлхий дахины хэмжээнд ч, цаашлаад Хятад улстай нягт харилцаатай байдаг. Япон улсын хувьд ч чухал ач холбогдолтой асуудал» (20-р тал) гэж үзээд түүнд аль болох үнэн зөв дүгнэлт өгөх зорилт тавьсан байна. Ингэхдээ тэрээр Хятадад шинэчлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх явцад гарч буй өөрчлөлт, ололт дутагдлыг улс ардын аж ахуйн салбаруудаар тодорхой харуулаад түүнтэй уялдуулж, хүн ам, хоол хүнсний асуудал, шинжлэх ухаан боловсролын салбарын хөгжилт зэрэг нийгэм-эдийн засгийн өргөн цар хүрээтэй асуудлуудыг түүний цаашдын төлөвтэй нь нягт уялдаа холбоотойгоор судалснаас гадна мөн хугацаанд БНХАУ-ын гадаад харилцаа цаашид ямар байдалтай хөгжих тухай Хятад-Зөвлөлт, Хятад Япон, Хятад-Гонконгийн хоорондын харилцааны жишээн дээр авч үзжээ. Тухайлбал, Япон-Хятадын харилцааны хувьд Хятадын талын тогтворгүй бодлогын улмаас 80-аад оны «нааштай харилцаанд» өөрчлөлт гарч болзошгүй юм гэсэн зохиогчийн санаа «Хятад, Япон хоёр улс үеийн үед найрамдалт харилцаатай байх болно» хэмээн зарлаж байгаа хятадын удирдагчдын одоогийн чиг бодлогоос ялгаатай байгаа нь харагдаж байна.

Зохиогч номдоо Хятадын өнөөгийн удирдлага, тэдний улс төрийн байр суурь, хоорондын зөрчил тэмцлийн асуудлыг авч үзжээ. М. Накажима Хятад улсын улс төрийн амьдралд Дэн Сяопиний гүйцэтгэж буй үүрэг, Хятадын нийгэм-эдийн засгийг хөгжүүлэхэд түүний хэрхэн нөлөөлж байгааг нэлээд тодорхой харуулсан байна.

Дэн Сяопин хоёр дахь удаагаа Хятадын улс төрийн тавцанд гарч ирсэн 1977 онд өөрийнх нь хэлснээр цаашид 8—10 жилийн турш биеийн байдал сайн байх болно гэснээс үзэхэд улс төрийн эрх барих хугацаа нь дуусч байгаа хэдий боловч үүнээс хойш түүнийг дахин 10 жил эсэн мэнд явж, түүгээр ч үл барам төрийн эрх барих боломжгүй болно гэж үзэж хэрхэвч болохгүй» (45-р тал) гэжээ. Гэвч 10 жилийн дараа Дэн Сяопин аргагүй халаагаа өгөх тэр үед Хятад улс социализмын замд эргэн орж, тууштай замнах боломж бүрэн байна (45-р тал) гэж дүгнэсэн байна.

Дэн Сяопиний улс төрийн чиг шугамыг хэвээр нь хэрэгжүүлэхийн тулд Хятад улсад цаашид шийдвэрлэвэл зохих улс төрийн хэд хэдэн зорилт үлдээд байгаа талаар зохиогч бичихдээ «Нэгд, 80-аад оноос хэ рэгжүүлж эхлээд ихээхэн удаашралтай явагдаж байгаа нам цэгцлэх

ажил; хоёрт, армийг шинэчлэх асуудал; гуравт, «нээлттэй хаалгын» бодлогыг эсэргүүцэж байгаа тодорхой хэсэг ХКН-ын дотор байгаа явдал юм» гээд энэ тодорхой хэсэгт ХКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Байнгын хорооны гишүүн Чэн Юнийг дурдаж «Чэн Юнь нар нь социализмын төлөвлөгөөт эдийн засгийн бодлогыг тууштай баримталж байгаа юм. Тэд ХКН-ын дотор хүчтэй дэмжлэгтэй байна» гэжээ. Зохиогч «Хятадын одоогийн удирдагчдаас түүвэр зохиол нь хэвлэгдэн гарсан хоёрхон хүн бол Дэн Сяопин, Чэн Юнь нар бөгөөд хэрэв ХКН ын дотор нууцаар санал хураавал олонхийн саналыг Чэн Юнь авч магадгүй» (39-р тал) гээд ийм зөрчил, өөрөөр хэлбэл одоогийн «нээлттэй хаалгын бодлогоо хэвээр баримталж өрнөдийн орнуудтай ойртсоор байх уу, эсвэл социализмын төлөвлөгөөт эдийн засгийн хөгжлийн зүй тогтлын дагуу улс орныхоо эдийн засгийг тууштайгаар дахин өөрчлөн байгуулах уу гэдэг зөрчилтэй асуудал хойшид ч үргэлжилсээр байх болно хэмээн хятадын дотоод байдлыг нэлээд бодитойгоор авч үзсэн байна.

М. Накажима Хятадын «Нээлттэй хаалгын» бодлого нь улс төр, үзэл суртлын талаасаа аж байдлаа сайжруулах гэсэн Хятадын нийгмийн дотоодын ерийн шаардлагыг илүү тусгаж байгааг (48-р тал) бичээд үүгээр Хятад улс социализмаас капитализм руу огцом эргэлт хийж, энэ чигээрээ «өрнөдөд ойртож» байгаа хэрэг биш юм, «нээлттэй хаалгын» бодлого нь хэрэг дээрээ «Мао маягийн социализмаас» (өөрийн хүчинд тулгуурлах—Б. С.) ухарсан боловч социализмыг өөрийг нь үгүйсгэсэн хэрэг биш» (48—49-р тал) гэж үзжээ.

Өнөөгийн Хятадын удирдагчдын баримталж байгаа бодлого нь зөвхөн л эдийн засгийн «нээлттэй хаалгын» бодлого юм. Хэрэв Хятад улс нэгэнт «нээлттэй хаалгын» бодлого явуулбал эдийн засгийн зэрэгцээ улс төр, үзэл суртлын талаар ч мөн тийм бодлого баримтлах хэрэгтэй байна гэсэн утга бүхий уг өгүүлбэр олонтаа дайралдаж байгаа нь хятадын «нээлттэй хаалгын» бодлогыг чамласан өнгө аястай төдийгүй хөрөнгөтний улс төр, үзэл суртлын нөлөөг Хятадын нийгмийн бүх салбарт гүнзгий дэлгэрүүлэхийг хичээж байгаа өрнөдийн ноёрхогч бүлгийнхний эрмэлзлэлийн илэрхийлэл болсон байна.

М. Накажима Хятадын нийгмийн амьдралд ардчиллын тухай шаардлага түүнчилэн гэмт хэрэг цаашид улам ихсэх хандлагатай болж байгаа нь Хятад улс гадаад ертөнцтэй харилцаагаа өргөжүүлж, Хятадын ард түмний ардчиллын үзэл санаа дээшлэх тутам түүнийг хязгаарлах явдал өссөнтэй холбоотой гэж үзжээ.

Мөн, ирээдүйд Хятад оронд хэвээр байх нийгмийн чанартай гол асуудлыг доорхи хэдэн зүйлээр авч үзжээ. Нэгд, улс орны шаардлага болон ажил мэргэжлийн байдлаас шалтгаалж гэр бүл тус тусдаа амьдрах явдлыг зогсоох, хоёрт, орон сууцаар хангах явдал томоохон асуудал болж байна. Үүний зэрэгцээ ажилгүйдлийн асуудал хэвээр үргэлжилж, хөдөө илгээгдсэн боловсролтой залуучуудын хот руу тэмүүлэх явдал ч улам өсөх, үүний улмаас кадр ажилтнуудад хээл хахууль өгөх явдал ч улам ихсэх хандлагатай байгааг бичжээ. (75-76-р тал)

Энэхүү номонд авч хөндсөн олон асуудлын дотроос Хятадын нийгмийн хөгжлийн ойрын хандлага болон нээлттэй хаалгын» бодлогын хойшдын төлөвийн талаар зохиогч М. Накажима хэрхэн бичсэнийг товч дурдахад ийм байна.

М. Накажимагийн бичсэн уг номд Хятадын нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг судалгааны үүднээс нэлээд бодитой авч үзсэн байна.

Б. Сэржав